



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 46

Мөрөн

Журам батлах тухай

Монгол улсын Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77, 79, 80 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 234 дүгээр тогтоол, Төрийн өмчийн хорооны 2009 оны 19, 232 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ыг 1 дүгээр, “Сумын болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга Л.Цэрэнжэвт, хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга Ж.Жавзанпагма, хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Г.Бөхсуурт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ПҮРВЭЭ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭД ҮНДСЭН ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ХУДАЛДАХ,
ШИЛЖҮҮЛЭХ, АКТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд /цаашид "хуулийн этгээд"/-ийн үндсэн хөрөнгө олж авах ажлыг төлөвлөх, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах ажлыг журамлан, төсвийн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулах, өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулахад оршино.

1.2 Хуулийн этгээд үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө /цаашид "үндсэн хөрөнгө"/-ийг олж авах, худалдах, шилжүүлэх, актлах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож, тайлагнахад энэхүү журмыг мөрдөнө.

1.3 Хуулийн этгээд нь үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах тухай санал ирүүлэхдээ дараахь бичиг баримт болон Орон нутгийн өмчийн албанаас баталсан маягтын дагуу мэдээллийг ирүүлнэ.

- ✓ Хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт
- ✓ Мэргэжлийн байгууллагын дүгнэлт
- ✓ Хөрөнгийн зах зээлийн үнийн судалгаа, худалдан авах дээд, худалдах доод үнийн санал
- ✓ Ашиглалтад орсон он, балансын анхны үнэ, үлдэгдэл үнэ, сүүлийн 3 жил оруулсан сэргээн босголтын зардал, тээврийн хэрэгслийн хувьд нийт гүйлт, арлын дугаар
- ✓ Балансаас балансад шилжүүлэх бол эзэмшигч болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн санал
- ✓ Харьяа дээд байгууллагын зөвшөөрөл
- ✓ Ашиглалтын хугацаа дуусаагүй боловч эвдрэл, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй хөрөнгийн эвдрэл, гэмтэл хуулийн этгээдэд учирсан хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагаас тогтоосон баримт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, хохирлыг барагдуулсныг нотлох баримт
- ✓ Газар эзэмшүүлэх болон ашиглуулах гэрээ, гэрчилгээ, барилгын төлөв байдлын улсын байцаагчийн дүгнэлт, барилгын хувийн хэрэг, гадна, дотор талын фото зураг /fail/, инженерийн сүлжээний техникийн зураг
- ✓ Тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон бусад техникийн баримт бичиг, улсын байцаагчийн дүгнэлт, фото зураг /fail/
- ✓ Механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспорт
- ✓ Сумын ИТХТ-ийн шийдвэр, Засаг даргын санал /энэ заалт хэлтэс, агентлагт хамаарахгүй/
- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр

1.4 Үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжөөс бусад балансын анхны үнэ 300,0 мянган төгрөгөөс доош өртөгтэй,

анхны өртөгөө нөхсөн, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар /Орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, аймгийн ЗДТГ-ын хувьд аймгийн Засаг даргын Захирамжаар/ шийдвэрлэнэ.

Хоёр. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ

2.1 Хуулийн этгээд нь үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу болон өөрийн үйл ажиллагааны илүүдэл зардлаас худалдаж авах, эсхүл орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

2.2 Хуулийн этгээд нь дараа онд хэрэгцээтэй байгаа орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдаж авах үндсэн хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, зардлыг тусгасан захиалгаа тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний дотор Өмчийн албанд ирүүлнэ.

2.3 Ажлын зайлшгүй шаардлагаар тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авах бол хуулийн этгээдийн ӨХБЗ-ийн санал дүгнэлтийн хамт захиалгаа ирүүлж хянуулна.

2.4 Өмчийн алба нь хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө худалдан авахаар ирүүлсэн захиалгыг судлан байгаа нөөц, хэрэгцээ шаардлага, хөрөнгийн ашиглалтын хугацаа, норм, норматив, зах зээлийн үнэ ханшийг баримтлан, автомашины хувьд Төрийн өмчийн хорооноос тогтоосон тоо, төрөлд багтаан хянаж тухайн жилийн 7 дугаар сарын 15-ны дотор аймгийн ЗДТГ-ын Санхүү Төрийн сангийн хэлтэст, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлнэ.

2.5 Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Өмчийн албанаас хянасан захиалгыг үндэслэн дараа оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компани нь Өмчийн албаар хянуулсан хөрөнгө оруулалтын жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

2.6 Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс нь орон нутгийн өмчийн барилга байгууламжид улсын болон орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар дараа онд хийх их засвар, өргөтгөл шинэчлэл, шинээр барилга байгууламж барих зэрэг ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа Өмчийн албатай зөвшилцөж, саналыг нь тусгана.

Гурав. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БҮРТГЭХ

3.1 Хуулийн этгээд нь энэ журмын 2.1-ийн дагуу олж авсан үндсэн хөрөнгийг хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаж, холбогдох үзүүлэлтээр нь Өмчийн албанд ирүүлж, орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлийн санд оруулна.

3.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд төсөл, хөтөлбөр, хандив тусламж, бэлэглэлээр шинээр бий болсон хөрөнгийн үнэ нь тодорхойгүй байвал Өмчийн

албатай хамтран "Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16"-д заасны дагуу тухайн үеийн зах зээлийн үнээр үнэлэн бүртгэнэ.

3.3 Улсын комисс нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бусад эх үүсвэрээр шинээр баригдсан барилга байгууламж, их засвар, өргөтгөл, шинэчлэлт, хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтад хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан баталгаажсан ажлын зураг төсөл, гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн акт, хүлээн авсан комиссын акт, ил далд ажлын акт зэрэг холбогдох бичиг баримтыг эзэмшигч хуулийн этгээдэд хүлээлгэн өгч, нэгдсэн жагсаалтыг Өмчийн албанд хүргүүлнэ.

3.4 Хуулийн этгээдийн захирал, нягтлан нь хүлээлгэн өгсөн баримтыг үндэслэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, барилга байгууламжийн Хувийн хэрэгт бичилт хийн Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан "Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл их засварын хувийн хэрэг хөтлөх журам"-ыг мөрдөж ажиллана.

3.5 Шинээр бий болсон эзэмшигч нь тодорхой бус хөрөнгийг Өмчийн алба хүлээн авч бүртгээд эрх бүхий байгууллагатай зөвшилцөн эзэмшигч хуулийн этгээдийг тогтоож, хөрөнгийг хүлээлгэн өгнө.

3.6 Дуусаагүй барилга, байгууламжийн гүйцэтгэлийн актыг үндэслэн тухайн хуулийн этгээд "Дуусаагүй барилга байгууламжийн бүртгэл"-д бүртгэнэ.

Дөрөв. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ

4.1 Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг худалдах асуудлыг аймгийн ИТХТ-ийн хурлаар шийдвэрлэж, гагцхүү дуудлагын худалдаагаар худалдана.

4.2 Дуудлагын худалдааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн ИТХТ-ийн 2010 оны 121 дүгээр Тогтоолоор баталсан "Дуудлага худалдаа явуулах журам"-ын дагуу зохион байгуулна.

4.3 Дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэгдсэн тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлж дуудлагын худалдааг зохион байгуулах ажлыг Өмчийн алба хариуцна.

Тав. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ

5.1 Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшилд шилжүүлэх асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

5.2 Хуулийн этгээд нь үндсэн хөрөнгө бусад хуулийн этгээдэд шилжүүлэх саналаа шилжүүлэн авах хуулийн этгээдийн саналын хамт Өмчийн албанд ирүүлнэ.

5.3 Хуулийн этгээдийн актлуулахаар санал ирүүлсэн үндсэн хөрөнгө бусад хуулийн этгээдэд засаж сэлбээд ашиглах боломжтой байвал балансаас балансад шилжүүлж болно.

5.4 Хуулийн этгээдийн хооронд үл хөдлөх хөрөнгө шилжиж байгаа тохиолдолд газар эзэмших эрх хамт шилжинэ.

Зургаа. ҮНДСЭН ХӨРӨНГӨ АКТЛАХ

6.1 Энэ журмын 1.4 - д зааснаас бусад үндсэн хөрөнгийг актлах асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

6.3 Хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг актлах асуудлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдийн даргын тушаалаар шийдвэрлэнэ.

6.3 Үндсэн хөрөнгийг сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглахаар шийдвэрлэсэн бол хуулийн этгээдийн санхүү акт үйлдэн, эргэлтийн хөрөнгийн данс бүртгэлд шинээр үнэлэн орлогод авах, устгах, худалдах, шилжүүлэх шийдвэр гарсан бол уг ажлыг Өмчийн алба зохион байгуулна.

Долоо. ҮНДСЭН ХӨРӨНГИЙГ ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХ, АКТЛАХ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ

7.1 Эрх бүхий байгууллагаас гаргасан үндсэн хөрөнгийн хөдөлгөөний шийдвэрийг Өмчийн алба үндсэн хөрөнгө эзэмшигч хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.

7.2 Шийдвэрийг хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаанд үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг тухайн хуулийн этгээдийн дарга, захирал хариуцна.

7.3 Хуулийн этгээд хөрөнгийн дотоодын тооллогыг жил бүр хийж хөрөнгийн хөдөлгөөний тайланг Өмчийн албанд ирүүлэх бөгөөд хөрөнгийн хөдөлгөөнийг Өмчийн албатай тулган, баталгаажуулалт хийнэ.

7.4 Өмчийн алба хөрөнгийн хөдөлгөөний тайланг нэгтгэж аймгийн ИТХТ, ЗДЗ-д танилцуулна.

Найм. ХАРИУЦЛАГА

8.1 Үндсэн хөрөнгө олж авах, актлах санал ирүүлэхдээ хуурамч материал бүрдүүлсэн болон энэхүү журмыг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан этгээдэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйл бусад хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

СУМЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Сумын болон Орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн /Хуулийн этгээд/ Өмч хамгаалах байнгын зөвлөл /ӨХБЗ/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Өмч хамгаалах байнгын зөвлөл

2.1 ӨХБЗ нь Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг эзэмших, зөв зохистой ашиглах, үр ашгийг дээшлүүлэхэд эрх зүйн зөвлөгөө өгөх, түүнд хяналт тавих, түүнчлэн шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах үндсэн хөрөнгийн талаар санал дүгнэлт гаргаж холбогдох материалыг хууль тогтоомж журмын дагуу бүрдүүлэх, энэ талаар эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцох, тайлагнах ажлыг тухайн хуулийн этгээд, сумын хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий хамтын удирдлагын хэлбэр мөн.

2.2 ӨХБЗ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын болон Төрийн өмчийн хорооны тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэр, өмчийн талаархи бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдлөг болгон ажиллана.

2.3 ӨХБЗ-ийг Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4-д заасныг үндэслэн хуулийн этгээдийн ӨХБЗ-ийг захирал /дарга/-ын шийдвэрээр, сумын ӨХБЗ-ийг сумын Засаг даргын Захирамжаар байгуулна.

2.4. Хуулийн этгээдийн ӨХБЗ-ийг хуулийн этгээдийн онцлогийг харгалзан 3-5 хүний бүрэлдэхүүнтэй, сумын ӨХБЗ-ийг сумын ЗДТГ-ын даргаар ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр /хуулийн этгээдийн төлөөлөл оролцох/ байгуулна.

Гурав. Хуулийн этгээдийн ӨХБЗ-ийн эрх, үүрэг:

3.1 ӨХБЗ нь хуулийн этгээдийн өмч хөрөнгийн бүртгэл тооллого, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар хийж гүйцэтгэх ажлыг жил, улирлаар төлөвлөн хуулийн этгээдийн дарга /захирал/-аар батлуулж, ажиллана.

3.2 Хуулийн этгээдийн хөрөнгийн тооллогыг жил бүр зохион байгуулж, дутагдуулсан, ашиглалтгүй байгаа, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн шалтгааныг тогтоож, дүгнэлт гарган гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

3.3 Хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа үндсэн хөрөнгийн тоо, хэмжээ, үнийн дээд хязгаар буюу зах зээлийн үнийн судалгаа,

техникийн болон бусад шаардлагын талаар зөвлөмж гаргаж гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

3.4 Өөрийн эзэмшилд байгаа илүүдэлтэй буюу элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн осол гэмтлийн улмаас болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэн акталж устгах, зориулалтыг нь өөрчлөх, шинээр олж авах асуудалд санал, дүгнэлт гаргана.

3.5 ӨХБЗ-ийн дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдийн дарга /захирал/ үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хийх хүсэлтээ сумын ӨХБЗ-д ирүүлнэ.

3.6 Хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг актлах асуудлыг судлан дүгнэлт гаргаж, хуулийн этгээдийн даргын тушаалаар шийдвэрлүүлнэ.

3.7 МУЗГ-ын тогтоол, Төрийн өмчийн хорооны тогтоол, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор батлагдсан журмын дагуу холбогдох маягтаар хуулийн этгээдийн эд хөрөнгийн тайлан, мэдээг холбогдох ажилтнаар хугацаанд нь гаргуулж Орон нутгийн өмчийн албанд ирүүлнэ.

3.8 ӨХБЗ-ийн шийдвэр байгууллагын даргын/ захирал/ тушаалаар баталгаажна.

Дөрөв. Сумын ӨХБЗ-ийн эрх, үүрэг:

4.1 ӨХБЗ нь тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн эзэмшилд байгаа өмч хөрөнгийн бүртгэл тооллого, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар хийж гүйцэтгэх ажлыг жил, улирлаар төлөвлөн ИТХТ-ээр батлуулж, ажиллах

4.2 ӨХБЗ нь тухайн хуулийн этгээдээс ирүүлсэн үндсэн хөрөнгийн хөдөлгөөний саналыг судлаж, сумын Засаг дарга, ИТХТ-д танилцуулан шийдвэрлүүлж аймгийн Орон нутгийн өмчийн албанд ирүүлэх

4.3 ӨХБЗ нь хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төсвөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, хандив, тусламж, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байдалд хяналт тавьж ажиллах

4.4 Эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсаны улмаас хэрэгцээт шаардлага хангахгүй болсон, тухайн үеийн зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан, зах зээлийн үнээс доогуур үнээр үнэлж, худалдан борлуулсан үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг хянаж, буруутай этгээдээр хохиролыг арилгуулах, зөрчил гаргасан этгээдэд арга хэмжээ авахыг байгууллагын даргаас шаардах эрхтэй ба гүйцэтгэлийг аймгийн ОНӨ-ийн албанд мэдэгдэх

4.5 Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдсаны орлогыг зөвхөн үндсэн хөрөнгийг сэргээн засварлах, шинээр бэлтгэхэд зарцуулах бөгөөд зарцуулалтад хяналт тавих

4.6 Түрээсийн орлого, зарцуулалт, түрээсийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавих

4.7 Хуулийн этгээдийн ӨХБЗ-ийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих

4.8 Хуулийн этгээдийн дарга /захирал/-тай байгуулсан Өмч эзэмшлийн гэрээний хэрэгжилтэд санал, дүгнэлт гаргах

4.9 Аймгийн ОНӨА-аас мэргэжил арга зүйн туслалцаа авч ажиллах

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1 Энэхүү журмыг зөрчсөн хуулийн этгээд, иргэн нь Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйл болон бусад хууль, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

оОо